

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ  
**БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ**

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН  
**МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ**

2016 оны 07 дугаар  
сарын 29 өдөр

Дугаар .....507/2016

Улаанбаатар-15171  
Утас: 323022, 328097  
Факс: 976-11-320338

<b>Объектын нэр:</b>	“320 хүүхдийн сургуулийн барилга”-ын холболтын ажлын зураг төсөл, төсөв <b>ШИФР: 15/14</b>		
<b>Объектын байрлал:</b>	Баян-Өлгий аймгийн Буянт сум		
<b>Хүчин чадал:</b>	320 хүүхдийн Тэнхлэгээрээ 47.8 м x 31.2 м, 24 м x 12 м хэмжээтэй S=2358 м <sup>2</sup>		
<b>Захиалагч:</b>	Баян-Өлгий аймгийн ЗДТГ		
<b>Санхүүжилтийн эх үүсвэр</b>	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар		
<b>Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгч:</b>	“ТГТ” ХХК		
<b>Регистрийн дугаар:</b>	РД: 2595699		
<b>Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:</b>	2016.08.26		
<b>Ажилбарын төрөл:</b>	1.2.3, 1.2.4, 1.2.6, 1.2.7 заалтын дагуу		
<b>Зураг төсөл боловсруулах үндэслэл:</b>			
Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо:	Баян-Өлгий аймгийн Буянт сумын Засаг даргын 2014.10.18-ны өдрийн 45 дугаар захирамж		
Зураг төсөл боловсруулах даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2014.06.12-ны өдрийн 05/2014 тоот зураг төсөл боловсруулах даалгавар		
Зураг төслийн гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Баян-Өлгий аймгийн Буянт сумын Засаг дарга, “ТГТ” ХХК-ийн захирал нарын хооронд 2014.10.17-ны өдөр байгуулсан 15/14 тоот зураг төсөл боловсруулах гэрээ		
<b>Техникийн нөхцлүүд:</b>			
<b>Техникийн нөхцлүүд:</b>	<b>Олгосон байгууллага:</b>	<b>Огноо:</b>	<b>Хүчинтэй хугацаа:</b>
Цахилгаан хангамж:	Баян-Өлгий аймгийн ЦШСГ	2014.11.14 14/116	-
Дулаан, ус хангамж	Өөрийн эх үүсвэр халаалтын зуухтай	-	-
<b>Зөвшөөрөлцсөн байгууллагууд:</b>			
Баян-Өлгий аймгийн Ерөнхий архитектор			Б.Мурат
Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын хэлтсийн улсын байцаагч			Х.Ербулан
<b>Зураг төслийн бүрэлдэхүүн:</b>			
Зургийн бүрдэл:	Зураг төслийн гүйцэтгэсэн байгууллагын нэр:	Шалгасан экспертийн нэр:	
Барилга архитектур:	“ТГТ” ХХК	С.Түмэн-Өлзий	

Барилга бүтээц:	"ТГТ" ХХК	М.Амаржаргал
Халаалт, агаар сэлгэлт:	"ТГТ" ХХК	Б.Лхамхүү
Ус хангамж, ариутгах татуурга:	"ТГТ" ХХК	М.Эрдэнэцэцэг
Цахилгаан хангамж:	"ТГТ" ХХК	Б.Түмэннаст
Төсөв:	"ТГТ" ХХК	П.Чимэддорж
Инженер геологийн судалгааны дүгнэлт:	"Алтайн хөрс" ХХК /Архив №156/2015/	Ж.Зулзагабаатар Дүгнэлт баталгаажсан
<b>Ерөнхий дүгнэлт:</b> /Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлээс/		
Барилга байгууламжийн техникийн ерөнхий өгөгдлийн болон техник-эдийн засгийн үзүүлэлт, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдлийн талаар тусгасан товч тодорхойлолт:	<p><b>Барилга байгууламжийн ерөнхий өгөгдөл:</b>                  "320 хүүхдийн сургуулийн барилга"-ын ажлын зураг төслийг Баян-Өлгий аймгийн Буянт сумын төвийн нутаг дэвсгэрт Засаг даргын 2014.10.18-ны өдрийн 45 дугаар захирамжаар олгогдсон 4800 м<sup>2</sup> талбайд байршуулахаар төлөвлөжээ.                  Төлөвлөж буй "320 хүүхдийн сургуулийн барилга"-ыг 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн БХТ-ийн 1429/2013 тоот Ерөнхий дүгнэлтээр баталгаажсан нэг маягын ажлын зураг төслийн холболтоор хийхээр зураг төслийг боловсруулсан байна.                  "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага" /БД 31-10-04/-ын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж барилгын гадна довжооны хэсэгт налуу зам төлөвлөсөн байна.</p> <p><b>Техник, технологи, дэд бүтцийн хангамж:</b>                  Барилгын талбайн хөрсний инженер геологийн судалгааны дүгнэлтийг "Алтайн хөрс" ХХК /Архив №156/2015 тоот/-д боловсруулсан ба газар хөдлөлийн 9 баллын бүсэд хамрагдаж байна.</p> <p>Улирлын хөлдөлтийн норматив гүн 3.36 м,                  Суурь суух буурь хөрсний механик шинж чанарын үзүүлэлт нь:                  Барьцалтын хүч: <math>C_n=2.0</math> кПа                  Дотоод үрэлтийн өнцөг <math>\phi^0=40^0</math>                  Хэв гажилтын модуль <math>E_0=45</math> мПа                  Тооцооны эсэргүүцэл <math>R=500</math> кПа</p> <p><b>Байгаль цаг уурын өгөгдөл:</b>                  Гадна агаарын температур <math>-31.3^0\text{C}</math>                  Цасны ачаалал <math>50</math> кг/м<sup>2</sup>                  Салхины ачаалал <math>35</math> кг/м<sup>2</sup>                  Галд тэсвэрлэлтийн зэрэг II</p> <p><b>Барилга байгууламжийн төлөвлөлт, хүчин чадал:</b>                  Тус барилгыг тэнхлэгээрээ 47.8 м х 31.2 м хэмжээтэй, 3 давхар, тэнхлэгээрээ 24 м х 12 м хэмжээтэй, 1 давхар спорт заалны хэсэгтэй байхаар төлөвлөсөн байна.</p> <p><b>1-р давхарт:</b> Спорт заал, спортын хэрэгсэл хадгалах өрөө, хувцас солих өрөө, ариун цэврийн өрөө, хооллох танхим, халуун цех, гал тогоо, ажилчдын хувцас солих өрөө, багшийн өрөө, 6 настай сурагчдад зориулсан хичээлийн танхим, тоглох өрөө, вестибюль, техникийн өрөөнүүдийг,  <b>2-р давхарт:</b> Хичээлийн танхим, багшийн хөгжлийн өрөө,</p>	

	<p>захирлын өрөө, бичиг хэргийн өрөө, сургалтын менежерийн өрөө, эмчийн өрөө, няравын өрөө, нягтлангийн өрөө, мэдээлэл зүйн танхим, ариун цэврийн өрөөг,  <b>3-р давхарт:</b> Номын фонд, урлагийн танхим, хөгжмийн агуулах, уншлагын танхим, хичээлийн танхим зэргийг тус тус төлөвлөжээ.  <b>Барилгын үндсэн бүтээц нь:</b>  <b>Суурь:</b> Цутгамал төмөр бетон шугаман суурьтай,  <b>Даацын үндсэн бүтээц нь:</b> Цутгамал төмөр бетон арагт бүтээцтэй,  <b>Хана:</b> 360 мм-ийн хөнгөн блокон, 100 мм хөөсөнцөр хавтан дулаалгатай, 120 мм зузаан тоосгон өрлөгтэй, өнгөлгөөний шавардлагатай;  <b>Хучилт:</b> Цутгамал төмөр бетон хавтан хучилттай,  <b>Дээвэр:</b> Хавтгай дээвэртэй байхаар тус тус төлөвлөжээ.  <b>Халаалт, агаар сэлгэлт:</b>                  Тус барилгын дулаан хангамжийг халаалтын уурын зуухнаас хангагдсан 2 хоолойт доороос түгээлттэй мухардмал системтэй байхаар төлөвлөсөн байна.                  Дулаан зөөгч усны параметр:                  2-р хэлхээнд 90°C /70°C                  Дулааны нийт ачаалал: Q=214.1 кВт                  Агаар сэлгэлтийн системийг механик болон ердийн агаар сэлгэлтийн системтэй байхаар тус тус төлөвлөжээ.  <b>Усан хангамж ариутгах татуурга:</b>                  Тус барилгын ус хангамжийг гүний худгаас, бохир усыг бохир усны худагт холбохоор төлөвлөсөн байна. Ус хангамжийн дамжуулах хоолойг цайрдсан ган хоолойгоор, ариутгах татуургын дамжуулах хоолойг хуванцар хоолойгоор угсрахаар төлөвлөжээ.  <b>Дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмж:</b>                  Тус барилга нь цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааны 3-р зэрэгт орох ба АВВБ маягын 3x185+1x70 мм<sup>2</sup> хөндлөн огтлолтой, хөнгөн цагаан голтой кабель шугамаар тэжээхээр мөн нэмэлт дизель генератор төлөвлөсөн байна.</p>
<p>Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаархи тодорхой санал, дүгнэлт:</p>	<p><b>Зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдлийг холбогдох орон тооны бус экспертүүд шалгаад:</b>                  Зураг төсөл нь барилгын норм ба дүрэм, стандартын шаардлага хангасан байна гэж дүгнэсэн байна.</p>

<p>Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан гаргасан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаархи дүгнэлт:</p>	<p>Тус сургуулийн барилга баригдсанаар хүүхдүүдийн сурч боловсрох таатай нөхцөл бүрдэж, оюуны хөрөнгө оруулалтыг дэмжих хүрээнд боловсролын салбарт томоохон ач холбогдолтой бүтээн байгуулалт хийгдэх юм. Урлагийн зал, номын сан, хооллох заал тусгасан нь нийгмийн ач холбогдолтой төлөвлөлт болсон байна.</p>
<p>Төсөв:</p>	<p><b>Эксперт нь:</b> Баян-Өлгий аймгийн Буянт сумын “320 хүүхдийн сургуулийн барилга”-ын ажлын төсөвт өртгийг <b>2 855 902 173</b> /хоёр тэрбум найман зуун тавин таван сая есөн зуун хоёр мянга нэг зуун далан гурван/ төгрөгөөр хянасан байна.                  1 м<sup>2</sup> барилга угсралтын ажлын төсөвт өртөг нь <b>926 490</b> /есөн зуун хорин зургаан мянга дөрвөн зуун ерэн/ төгрөг байна.</p>

“Барилгын тухай” Монгол Улсын хуулийн /шинэчилсэн найруулга 2016 он/ 38.1.2-т “барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх”, 38.1.3-т “зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх”, 39.4-т “Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээх”, 39.5-д заасны дагуу “Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаархи дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ”.

Баян-Өлгий аймгийн Буянт сумын нутаг дэвсгэрт баригдах “320 хүүхдийн сургуулийн барилга”-ын ажлын зураг төсөл, төсөвт “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм”, “Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм” /БНБД 81-94-12/, “Төсөв зохиох дүрэм” /БНБД 81-95-12/, Баян-Өлгий аймгийн Буянт сумын Засаг даргын 2016.06.20-ны өдрийн 1/123 тоот албан бичгийг тус тус үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, ерөнхий дүгнэлт бичсэн болно.

Ерөнхий дүгнэлт нь экспертүүдийн 11 хуудас магадлалын хавсралт дүгнэлтийн хамт хүчинтэй.

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
 ЗАХИРАЛ

МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН  
 ДАРГА

МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН  
 МЭРГЭЖИЛТЭН



Б.БАЯРСАЙХАН

Г.МӨНГӨНХУЯГ

Б.БАЯРЦЭНГЭЛ